

ТАВААРЫН
ЗАХ ЗЭЭЛИЙН
ДОЛОО
ХОНОГИЙН
ТОЙМ

Алт
Газрын тос



АЛТНЫ ДОЛОО ХОНОГИЙН ТОЙМ

2022 оны 8-р сарын 8

Өнгөрсөн ба энэ долоо хоногийн онцлох үйл явдал:

Өнгөрсөн долоо хоногт алтны ханш 0.54 хувиар өслөө. Харин шинэ долоо хоног эхлэхэд ам.долларын ханш бага зэрэг чангарч алтны ханш бага зэрэг уналаа.

Баасан гарагт АНУ-ын ажлын байр таамаглаж байснаас маш сайн үзүүлэлтэй гарч эдийн засгийн хямралын талаарх түгшүүрийг бууруулж, холбооны нөөцийн сан бодлогын хүүг илүү эрчтэй нэмэгдүүлэх магадлалтай тул алтны ханш суларлаа.

Хөдөлмөр эрхлэлтийн эерэг дүр зураг нь ХНС-д эдийн засгийг уналтад оруулах эрсдэлгүйгээр бодлогын хүүгээ өсгөх боломжийг олгож байгаа бөгөөд алтны өсөлт 1800 доллараар хязгаарлагдах магадлалтай гэж шинжээчид тэмдэглэлдээ дурджээ.

Долларын индекс 0.8%-иар өссөн нь АНУ-ын сангийн өгөөж энэ мэдээллийн дараа өсөлтөө үргэлжлүүлэв.

Харин Тайванийн асуудлаар БНХАУ болон АНУ-ын хооронд хурцадмал байдал үүссэнтэй холбоотойгоор Хятад дахь алтны үнэ өсөв.

Хэрэв геополитикийн асуудал гарвал алт өсөх хэдий ч энэ нь тогтвортой өсөлт байж чадахгүй.

Golomt_Capital published on TradingView.com, Aug 08, 2022 10:24 UTC+8

Gold Spot / U.S. Dollar 1YK CANADA Q1775.800 H1775.800 L1771.220 C1774.965 -0.835 (-0.05%)
1M (50, close, 0, SMA, 5) 1822.096
1M (100, close, 0, SMA, 5) 1825.480



TradingView

Мэдэгдэл: Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.



ГАЗРЫН ТОСНЫ ДОЛОО ХОНОГИЙН ТОЙМ

2022 оны 8-р сарын 8

Өнгөрсөн ба энэ долоо хоногийн онцлох үйл явдал:

БНХАУ-ын газрын тосны хэрэглээ сул байгаа нь эрэлтийг бууруулж, газрын тосны ханш өнгөрсөн долоо хоног 9.74 хувиар уналаа.

БНХАУ-ын долдугаар сарын газрын тосны импортын хэмжээ өмнөх сарынхаас их байсан ч таамаглаж байснаас сул өссөн. Гэсэн хэдий ч экспорт тогтвортой хэвээр байгаа тул Хятад улс түүхэн дээд хэмжээний худалдааны ашиг авчээ.

БНХАУ-ын эдийн засгийн идэвхжил хөл хорионоос болж ихээхэн уналтад орсон бөгөөд өнгөрсөн долоо хоногт хийсэн албан ёсны мэдээллээс харахад үйлдвэрлэлийн салбар долдугаар сард буурсан байна.

Баасан гаригт АНУ-ын ажил эрхлэлтийн мэдээллүүд хүлээгдэж байснаас илүү хүчтэй гарсан нь хөрөнгө оруулагчид ирэх сард АНУ-ын Холбооны нөөцийн сангаас бодлогын хүүгээ огцом өсгөнө гэж найдаж байгаа нь нефтийн зах зээлд сөрөг нөлөө үзүүлжээ.

Шатахууны үнэ өссөн инфляцид хамгийн том нөлөө үзүүлсэн тул газрын тосны үнэ цааш буурах нь инфляцийн дарамтыг бууруулж магадгүй.

Энэ долоо хоногийн сүүлээр АНУ, Хятад, Евро бүсийн инфляцийн мэдээлэл хүлээгдэж байна. Хүлээгдэж байснаас өндөр үзүүлэлттэй гарвал ХНС-аас мөнгөний чангаралтыг нэмэгдүүлж, нефтийн үнийг улам бууруулж болзошгүй юм.

Golomt_Capital published on TradingView.com, Aug 08, 2022 10:51 UTC+8



Мэдэгдэл: Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.